

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023
оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/401
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын Эрүүгийн цагдаагийн болон
Нийтийн хэв журам хамгаалах тасаг

Албан тушаалын нэр:

Байцаагч
/Экологийн асуудал хариуцсан/

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-8

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц
халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад
аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй
байдал үүссэн, террорист халдлага, онц болон
дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг
үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд
уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн
байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Зөрчлийн тухай хуульд заасан харьяалах зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, Зөрчил
шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт
явуулах, хариуцсан нутаг дэвсгэрт зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нууц далд аргаар
үйлдэгдсэн, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар илрүүлэх, нийтээр
дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж
ажиллах.

Албан тушаалын зорилт:

1. Хариуцсан нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдсэн, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар илрүүлэх,
2. Харьяалах зөрчлийн талаарх гомдол мэдээлэл, зөрчлийн хэрэгт Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах,
3. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, бусад албадтай хамтран ажиллах,
4. Объекын төрөлжсөн бүртгэл судалгааг хийж, сан бүрдүүлсэн гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах,
5. Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын болон шалгасан гэмт хэрэг, зөрчлийн дүн мэдээг экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгчид өгч нэгтгүүлэх,
6. Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1. Тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Эрэн сурвалжлах ажил явуулах /код 229/ журам”, “Гүйцэтгэх ажил явуулах /код 307/ журам”-д заасны дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, 1.2. Хариуцсан нутаг дэвсгэрт нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргүүдийн нөхцөл байдлын судалгааг гаргаж, мэдээллийн эх сурвалжийн сүлжээг зохион байгуулна, 1.3. Гүйцэтгэх ажлын шугамаар олсон мэдээллийг “Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын заавар”-т заасан үндэслэл журмын дагуу баримтлан шалгаж шийдвэрлэнэ. 1.4. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд зайлшгүй хийвэл зохих ажиллагааг гүйцэтгэх ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэхээр ирүүлсэн даалгаварт гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа зохиож хариу өгнө.	Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэргийн илрүүлэлтэд ахиц гарна.	Т, Г Т, Г Т, Г,
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон холбогдох эрх зүйн актаар харьяалуулсан зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах,	Зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд ахиц гарна.	Г

	2.2. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан заалт нэг бүрийг бүрэн хэрэгжүүлж ажиллах, 2.3. Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, албаны тусгай хэрэгсэл хэрэглэх, шинжилгээнд дээж эд зүйл хүргүүлэх, ажлыг хэрэгжүүлэх,		Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Цагдаагийн албаны тухай хууль болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, 3.2. Цагдаагийн ерөнхий газар, албаны даргын тушаалаар батлагдсан дүрэм журам зааврыг хэрэгжүүлж ажиллах, 3.3. Зөрчлийн хэргийн бодит байдлыг тогтоох, илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, олж тогтоох ажлыг гүйцэтгэх, 3.4. Зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдэгдсэн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор иргэн аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл, шаардлага хүргүүлэх, үр дүнг тооцох,	Алба хаагчдын ур чадвар нэмэгдэж, хуулийн хэрэгжилт бодитой, үнэлэлт дүгнэлт өгөгдөнө.	Г Г Г Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. "Хөтлөх бүртгэл судалгааны жагсаалт"-нд заасан бүртгэлүүдийг биечлэн хөтөлнө. 4.2. Сэжигтэй этгээд, байр байгууламжийг илрүүлэн санд оруулж, хяналт тавьж ажиллана. 4.3. Объектын судалгааг заавар, журам, албан даалгавар, стандарт, аргачилсан зөвлөмжийн дагуу хийнэ.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажил сайжирна.	Г Г Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг танилцуулах, 5.2. Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын болон шалгасан гэмт хэрэг, зөрчлийн дүн мэдээг экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгчид өгч нэгтгүүлэх	Ажлын гүйцэтгэл сайжирна.	Г Г
6 дугаар зорилтын хүрээнд	6.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх, 6.2. Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн,	Хуулиар хүлээлгэсэн нийтлэг чиг үүргийн хэрэгжилт хангагдана.	Г Г

	“Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн чанд мөрдөх 6.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах,		Г
--	---	--	---

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Аюулгүй байдал /1032/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Ахлагчийн албан тушаалд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байх		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах, - Судалгааны арга зүйн мэдлэгтэй;	
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; - Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах;	
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;	
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.	

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.


V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Байгууллагын нэр:
Шийдвэрийн огноо:
Дугаар:.....



Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.12.27

Дугаар: А/401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр



ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:

.....
.....
.....

2023 оны дугаар сарын-ны өдөр